

СУЛ ОРОН ТООНЫ ЗАР

2025.03.10

Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг үндэслэн Үндэсний аудитын газарт Стратеги төлөвлөлтийн газрын “Статистик, дүн шинжээч хариуцсан шинжээч”-ийн албан тушаалын сул орон тоог зарлаж байна.

Нэг. Албан тушаалд тавигдах шаардлага

1. Албан тушаалд тавигдах ерөнхий шаардлага

- Монгол Улсын иргэн байх;
- Дээд боловсролтой байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй;
- Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх (эрэгтэй);
- Төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагч эсхүл төрийн жинхэнэ албаны нөөцөд байх;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг бүрэн хангасан байх;

2. Албан тушаал тавих тусгай шаардлага

2.1.“Статистик, дүн шинжилгээ хариуцсан шинжээч”-ийн албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	-Математик, статистик /0541, 0542/;
Мэргэшил	-Төрийн албанд мэргэшүүлэх эсхүл түүнтэй адилтгах сургалтад хамрагдаж төгссөн байх.;
Туршлага	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.

Хоёр. Шалгалт өгөхийг хүссэн албан хаагч бүртгүүлэхдээ дор дурдсан бичиг баримтыг бүрэн ирүүлнэ. Үүнд:

- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшнийг тодорхойлсон баримт бичгийн хуулбар (диплом) Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар
- Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар эсхүл Цахим лавлагаа (“e-mongolia”- аас татан авах);
- “4 х 6”-ийн хэмжээний цээж зураг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт.
- Төрийн албанд ажилласан жил тооцох зорилгоор албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (e-mongolia–аас татан авах) ;
- Төрийн жинхэнэ албан хаагч бол сүүлийн 1 жилийн дотор ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээгээгүйг нотлох бичиг баримт;

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх

Албан тушаалын орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад оролцох албан хаагч, иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 12:00 цаг хүртэл Үндэсний аудитын газрын 306 тоотод хүлээн авна.

Дөрөв. Хүсэлт ирүүлсэн албан хаагчдад мэдээлэл хүргэх:

Орон тоо нөхөх тусгай шалгалт өгөх хүсэлт ирүүлсэн албан хаагч, иргэний бичиг баримтыг хянаж, албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан эсэхийг ирүүлсэн бичиг баримтаар болон ярилцлагаар шалгаруулж, шаардлага хангасан албан хаагч, иргэнд тусгай шалгалтыг зохион байгуулах хугацааг албан хаагчийн цахим хаягаар мэдэгдэнэ.

Холбоо барих утасны дугаар
Үндэсний аудитын газар: 51-261585

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР